

ЗӨВЛӨЛТ СУДЛАЛЫН МОНГОЛЫН ХОЛБОО БАЙГУУЛАГДЛАА

ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтдийн санаачилгаар Монголын Зөвлөлт судлалын холбоо байгуулах хурал энэ оны 6 дугаар сарын 27-нд болов.

Уг хуралд холбооны дүрэм, холбооноос 1991 онд хийх ажлын төлөвлөгөөг баталж, Тэргүүн, дэд тэргүүнийг сонгов. Холбооны тэргүүнээр БНМАУ-ын ШУА-ийн гишүүн, ЗСБНХУ-ын ШУА-ийн гадаад гишүүн доктор, профессор Б. Ширэндэв, дэд тэргүүнээр Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор профессор Х. Дашдондовыг сонголоо.

Монголын Зөвлөлт судлалын холбоо нь Зөвлөлтийг судалдаг эрдэмтэд, байгууллага, хамтлагуудын хүчийг нэгтгэж, тэдний үйл ажиллагааг зохицуулж, Зөвлөлт судлалыг тодорхой чиглэлтэйгээр хөгжүүлэх зорилготой сайн дурын байгууллага юм. Тэрээр Монгол-Зөвлөлтийн ард түмнүүдийн уламжлалт харилцааг бэхжүүлэх, шинэ шатанд хоёр орны бүх талын хамтын ажллагааг хөгжүүлэх шинэ бололцоо, нөхцөлийг бүрдүүлэхэд багагүй хувь нэмэр оруулах учиртай.

Холбооны эрдэм шинжилгээ судалгааны ажлын зорилт, чиглэлийг холбооны зөвлөл (15 хүнтэй) тодорхойлж, зохицуулж байх бөгөөд тэргүүн, дэд тэргүүн нар нь холбооны өдөр тутмын ажлыг удирдан явуулж байх юм.

Зөвлөлт судлалын холбооны орлого нь гишүүдийн татвар, элсэлтийн хураамж, сайн дурын хандив зэргээс бүрдэнэ. Холбоо нь «Монголын зөвлөлт судлалын холбоо» гэсэн тэмдэг, албан хуудастай байна.

Зөвлөлт судлалын Монголын холбооны зохион байгуулах хурлын дараа холбооны тэргүүн Б. Ширэндэвтэй уулзан холбооны зорилго, үйл ажиллагааны талаар асууж сонирхоход тэрбээр

— Зөвлөлт судлалын холбоо бол эрдэм шинжилгээ судалгаа явуулах эрдэм номын байгууллага болохоос олон нийтийн байгууллага биш. Манай иргэдээс олон хүн Зөвлөлтөд суралцсан, ажлаар очдог хэвлэл мэдээллийн шугамаар Зөвлөлтийн тухай өргөн мэдэж байдаг боловч Зөвлөлтийг тусгайлан судлах ажил урьд өмнө явагдаагүй. Зөвлөлт судлал өргөн цар хүрээтэй, тэр бүгдийг бидний цөөн хүмүүс хамарч чадахгүй. Иймээс гол асуудлыг сонгон авч, түүнийгээ хэдэн сэдэв болгон задлаж судалгаа явуулах санаатай. Тэр гол асуудал гэдэг бол одоо үед манай улс болон олон улсын анхаарлыг татаж буй өөрчлөн зохион байгуулалтын асуудал юм. Энэ асуудал ч нэн өргөн хүрээтэй учраас хэсэг цөөн сэдвийг, юуны өмнө сонгон авч судалбал зүйтэй мэт. Жишээлбэл, ЗХУ-д анх удаа үүсгэн санаачилсан улс төрийн шинэ сэтгэлгээний үүднээс Ази, Номхон дөлгөөн далайн орнуудын харьцааг судлах нь олон улсын харилцааны үүднээс ч гэсэн, манай улсын явуулж буй гадаад бодлогын үүднээс ч чухал асуудал юм. Зөвлөлтөд хийгдэж буй улс төрийн өөрчлөн зохион байгуулалт, эдийн засгийн хямралаас гарахаар зохиож буй ажил зэрэг нь бидний анхаарлыг зүй ёсоор татаж байдаг юм. Үүнээс гадна бас хэдэн сэдэв байх болов уу гэж бодож байна. Дээрх судалгаануудыг хийснээр Зөвлөлт улсад явагдаж буй өөрчлөн зохион байгуулалтын явцыг бид харгалзаж үзэх нь хөрш орны хувьд хэрэгтэй мэт. Энэ судалгаа явуулахад бид зохих мэргэжлийн хүмүүсийг хамааруулан сайн дурын үндсэн дээр хийх болно.

Холбоо дөнгөж байгуулагдаж байгаа болохоор судалгааны чиглэл, сэдвийг сонгон авч төлөвлөхөөр завдаж байна хэмээн өгүүлэв.